



ЕБС-ИЙН VI-IX АНГИЙН ТҮҮХИЙН СУРАХ БИЧИГТ АШИГЛАСАН БИЧГИЙН СУРВАЛЖ, АСУУЛТ, ДААЛГАВАРТ ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

Х.Баярмаа^а

^аМУБИС, Нийгэм, Хүмүүнлэгийн Ухааны Сургууль, ахлах багш, доктор

Холбоо барих зохиогч: Bayarmaa.kh@msue.edu.mn 

Хүлээн авсан: 2024.08.25

Хянагдсан: 2024.09.20

Зөвшөөрсөн: 2024.10.25

Хураангуй

Энэхүү өгүүлэлд 2014-2015 оны суурь боловсролын шинэчлэлийн хүрээнд шинээр боловсруулж, өнөө сургалтад хэрэглэж буй VI-IX ангийн түүхийн сурах бичигт ашигласан бичгийн сурвалжуудын талаар авч үзсэн болно. Ингэхдээ эдгээр эх сурвалжийн зохиогч, нэр, он цагийг тодорхой заасан эсэх, сэдэвт холбогдох байдал, бичгийн сурвалжийг сонгон авах шалгуурт нийцсэн эсэхийг тухайлан авч үзлээ. Мөн бичгийн сурвалжтай ажиллах асуулт, даалгаврыг сурвалж судлалд баримталдаг бичгийн сурвалжийг задлан шинжлэх алхамуудтай харьцуулан нийцэж буй эсэхэд дүн шинжилгээ хийсэн болно. Эдгээр сурах бичгийн зохиогчид эх түүх болон дэлхийн түүхэн цаг үед холбогдох, олон төрлийн, дээр нь түүхийн судалгаанд өргөн хэрэглэдэг, үнэ цэнтэй, зарим талаар өмнө нь сургалтад төдийлөн ашиглаж байгаагүй бичгийн сурвалжийг эрж хайх, цуглуулах, хэсэглэн авч ашиглах зэргээр нэр их ажил хийсэн байна. Сурах бичигт бичгийн сурвалжийг ийм өргөнөөр ашигласан нь сайн хэдий ч бичгийн сурвалжийн зохиогч, он цаг, нэрийг заах, шалгуурт нийцүүлэн сонгон авах, бичгийн сурвалжийг задлан шинжлэх асуулт, даалгаврыг оновчлох зэргээр засан сайжруулах олон асуудал байгааг өгүүлэлдээ дурдах болно. Сурах бичигт ашиглах бичгийн сурвалжийг шалгуурт нийцүүлэн сонгон авах, задлан шинжлэх асуулт, даалгаврыг сурвалж судлалын судалгааны үе шатад нийцүүлэн боловсруулснаар оновчтой боловсруулах нь сурагчдын танин мэдэх бие даасан үйл ажиллагааг зөв, арга зүйн үндэстэй зохион байгуулах юм.

Түлхүүр үг

Түүхийн эх сурвалж, бичгийн сурвалж, эх сурвалжийн тодорхойлолт, эх сурвалжийг сонгон авах шалгуур, эх сурвалжийг задлан шинжлэх асуулт, даалгавар

Удиртгал

2014-2015 оны хичээлийн жилээс Монгол улсын Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын хөтөлбөрийг шинэчилсний дотор түүхийн сургалтад эрс өөрчлөлтийг хийсэн гэж болно. Суурь боловсролын VI-IX ангид дэлхийн түүх, монголын түүхийг эрт, дунд, шинэ, нэн шинэ үе гэсэн он цагийн дарааллаар зэрэгцүүлэн судлах болсны дээр түүхийн хичээлээр шинжлэн судлах арга барил эзэмшүүлэх нь суралцахуйн зорилт болж, хөтөлбөрт нийцүүлэн сурах бичгүүдийг шинээр боловсруулсан юм.

2019 онд шинэ хөтөлбөрийн хэрэгжилтийн эхний үнэлгээ, судалгаа хийгдэж, хөтөлбөр, сурах бичгийн агуулга, арга зүйг сайжруулсан байна.

Эдгээр сурах бичиг нь “Түүх VI” (зохиогчид П. Дэлгэржаргал, У. Туяа, Б. Чинзориг, Д. Янжинжав), “Түүх VII” (зохиогчид А.Алтанбагана, Х.Баярмаа, Ж.Гэрэлбадрах), “Түүх VIII” (зохиогчид Ц.Гантулга, Л.Алтанзаяа, Б.Нацагдорж, Д.Пунцагсүрэн, М.Цогбаяр), “Түүх IX” (зохиогчид С.Амарсанаа, О.Батсайхан, З.Лонжид, Д.Нансалмаа, О.Оюунтунгалаг, Б.Пунсалдулам, У.Туяа) юм. Сурах бичгийн зохиогчдоос судлаач Л.Алтанзаяа, Ц.Гантулга, П.Дэлгэржаргал, У.Туяа нар эх түүх болон дэлхийн түүхийн сурах бичиг бичих ихээхэн туршлагатай зохиогчид байна.

Үндсэн хэсэг гарчиг 1

Бид эдгээр сурах бичгийн агуулга, арга зүйг бүхэлд нь шинжлэх зорилго тавиагүй харин сурах бичигт орсон бичгийн сурвалжийг (баримт бичиг) сонгон судаллаа. Учир нь дээрх сурах бичгүүдэд сурагчдын бие даасан танин мэдэх үйлийг зохион байгуулах үндсэн хэрэглэгдэхүүн болох бичгийн сурвалжийг олноор ашигласан юм.

Ингэхдээ эдгээр эх сурвалжийн сэдэвт холбогдох байдал (нийцэмж), зохиогч, нэр, он цагийг тодорхой заасан эсэх (эх сурвалжийн тодорхойлолт), бичгийн сурвалжийг сонгон дидактик болон түүхийн мэдэх шалгуурт нийцсэн эсэхийг шалгуурт нийцсэн эсэхийг тухайлан авч үзлээ. Мөн бичгийн сурвалжтай ажиллах асуулт, даалгаварт дүн шинжилгээ хийсэн болно.

Үндсэн хэсэг гарчиг 2

VI-VII ангийн “Түүх VI”, “Түүх VII” сурах бичигт ашигласан бичгийн сурвалжийг “Сурвалжийн мэдээ”, “эх сурвалж” гэсэн тэмдэглэгээгээр тусгайлан ялгасан бол VIII, IX ангийн “Түүх VIII”, “Түүх IX” сурах бичигт арын дэвсгэр өнгөөр ялган заримыг нь “баримт 1, 2” гэж дугаарлаж, IX ангийн 12 бичгийн сурвалжийг “тодруулга” нэрээр оруулсан байна.

Сурах бичгийн зохиогчид эх түүх, дэлхийн түүхийн янз бүрийн үед холбогдох шинжлэх ухааны үндэслэлтэй мэдлэг, чадвар олгоход чиглэсэн агуулга бүхий өмнө нь сурах бичигт ороогүй бичгийн сурвалж ашиглах талаар ихэд анхаарсныг тэмдэглэх хэрэгтэй.

VI ангид эртний Монголын түүхэнд холбогдох 6 эх сурвалж, дэлхийн түүхийн 1 эх сурвалж, VII ангийн сурах бичигт дундад зууны Монголын түүхэнд холбогдох 14

эх сурвалж, дэлхийн түүхэнд холбогдох 13 эх сурвалжаас нийтдээ 90 удаа хэсэглэн авсан (90 эх сурвалжийн 28 нь “Монголын нууц товчоо”-ноос, 21 нь Рашид ад Диний “Судрын чуулган”-аас эшилжээ), VIII ангийн сурах бичигт Монголын түүхэнд холбогдох 17 эх сурвалж, дэлхийн түүхэнд холбогдох 12 эх сурвалж, нийт 29 эх сурвалжаас 41 удаа эшилсэн, IX ангид Монголын түүхэнд холбогдох 28 эх сурвалж, дэлхийн түүхэнд холбогдох 2 эх сурвалж, нийт 30 эх сурвалжаас 34 удаа хэсэглэн авч ашигласан байна. 4 сурах бичигт нийтдээ 93 бичгийн сурвалжаас 172 удаа хэсэглэн авч ашиглажээ (Хүснэгт 1).

Хүснэгт 1. VI-IX ангийн сурах бичигт орсон бичгийн эх сурвалжийн тоон үзүүлэлт

№	Анги	Монголын түүх		Дэлхийн түүх		Нийт
		Эх сурвалжийн тоо	Ишилсэн тоо	Эх сурвалжийн тоо	Ишилсэн тоо	
1.	VI	6	6	1	1	7/7
2.	VII	14	76	13	14	27/90
3.	VIII	17	26	12	15	29/41
4.	IX	28	32	2	2	30/34
	Нийт	65		28		93/172

Эх сурвалж: Судлаачийн загвар

Эдгээр бичгийн сурвалжийн үнэ цэн, ач холбогдол эргэлзээгүй, сэдэвт холбогдох эх сурвалжийг сонгон авахад зохиогчид няхуур хандаж, цөөн тохиолдлыг эс тооцвол эх сурвалж бүр судалж буй сэдвийн агуулгад бүрэн нийцэж байна.

Ийнхүү сэдэв бүрт бичгийн сурвалж ашигласан нь сайшаалтай боловч бас сөрөг талтай нь харагдаж байна. Сэдэв бүрийн эхэнд сурвалжийн мэдээ тавьж, суралцагчаар таамаглал дэвшүүлэх боломж олгосон боловч сэдвийн үндсэн хэсэг, төгсгөл хэсэг, асуулт, даалгаварт ч эх сурвалжийн мэдээ оржээ. Энэ нь сурагчдад ачаалал үүсгэж, залхаах, сурвалжийн үнэ цэнийг бууруулах сөрөг талтай байна. Тухайлбал, VII ангийн “VI-XII зууны Монгол аймаг улсууд”, “Монголчуудын ахуй амьдрал, соёл”, VIII ангийн “Нэгдмэл хүчирхэг байдлаа сэргээхийн төлөө тэмцэл” сэдэвт 7-10 эх сурвалжаас хэсэглэн авсан байна. Мөн IX ангийн “Бурхны шашин ба социализм” хэмээх сэдвийг дурдаж болно.

Зохиогч сурах бичгийн үндсэн эхэд түүхийн сурвалжаас ашиглахдаа өөрийн хэлсэн санааг батлах, бичиж буй зүйлээ илүү үнэмшил, нотолгоотой болгох зорилго агуулдаг бол зарим сурах бичигт эхийн нэг догол мөр нь зохиогчийн үгээр үргэлжлэл нь эх сурвалжаас эшилсэн зүйл байгаа нь сурагчид уншиж ойлгоход тун хүнд байна. Жишээ, VIII ангийн сурах бичгийн “Нэгдмэл хүчирхэг байдлаа сэргээхийн төлөө тэмцэл” сэдэвт “Алтан хан Түмэдэд тариа тариулан, гар урлал хөгжүүлж, “Байшин” хэмээх хот байгуулсан нь хожим Өвөр Монголын төв Хөх хот болжээ” гээд дараагийн догол мөр нь “Алтан Хөх хотонд суугаад, Гэгээн хаан хэмээн өргөж, газар газарт байлдан дайлж, Ойрадыг давчилгаад Төвөд улсын янад хязгаар дахь Амдо, Шарай гол аймгийг дагуулав. Бас Мин улсын хязгаар хотыг байлдаж, хот балгасыг давчилахуйд Мин улсын Лун Цин хаан (1567-1573) жил бүр алт, торго хүргэж, Шунь и ван хэмээн цол өргөжээ. Дарайсун хаан сууринд найман

жил сууж нөхчив. Хөвгүүн Түмэн засагт залгамжлав” (Ломи. Монголын боржигод овгийн түүх-ээс) гэсэн эх сурвалжийн мэдээгээр үргэлжилж байна (Гантулга, 2019, хууд. 21). Түүхийн сурвалж бол угаас сургалтын зориулалтгүй тул зохиогчийн бичвэрээс ялган тусгайлан оруулж, асуулт, даалгавар боловсруулдаг.

Сурах бичигт ашиглаж байгаа эх сурвалжийн зохиогч, нэр, он цагийг заах нь эх сурвалжийн талаар сурагчид бүрэн төсөөлөхөд тусалдаг. Мөн эдгээр эх сурвалжийг багш, сурагчид цаашид судлах, ашиглахад дөхөм болдог. Харамсалтай нь сурах бичгийн зохиогчид бичгийн сурвалжийн зохиогч, нэр, он цаг, бичгийн сурвалж үүссэн нөхцлийн талаар яв цав, тодорхой мэдээлэхэд зүй ёсны анхаарал хандуулаагүй байна.

Ийм жишээг дээрх сурах бичгийн олон сэдвээс харж болно (Хүснэгт 2).

Хүснэгт 2. Сурах бичигт орсон бичгийн сурвалжийн тодорхойлолт

Бичгийн сурвалжийн тодорхойлолт	Сурах бичиг			
	Түүх VI	Түүх VII	Түүх VIII	Түүх IX
Зөвхөн он цагийг заагаагүй	48-р тал. <i>Хаммурапи хааны хуулиас,</i> 79-р тал. <i>Хожуу Хан улсын судар</i> ”-ын мэдээгээр	117, 130-р тал “ <i>Пап лам VII Григорийн (1073-1085) зарлигаас</i> ”	15, 18, 19, 20, 21, 22, 30, 44, 77, 79, 81, 104, 117, 119, 128, 129-р тал	43, 48, 56, 75-р тал <i>Шинэ эргэлтийн бодлогын үед “Үнэн” сонинд нийтлэгдсэн эх сурвалж</i>
Зохиогчийг заагаагүй		72, 79-р тал		
Эх сурвалжийн нэр заагаагүй	73-р тал <i>НТӨ 176 онд Модунь шаньюй Хан улсын хуандид бичсэн захидалдаа</i>	48, 111-р тал <i>Франческо Балдуччи Пеголит гэгчийн 1340 онд бичсэн номын хэсэг</i>	54, 87, 103-р тал <i>1907 онд Манжийн төрөөс монгол хошуудын талаар судалгаа хийв...энэ байцаалтад...</i>	
Эх сурвалжийн зохиогч, нэр, он цагийг заагаагүй.	73-р тал <i>Эх сурвалж 2</i>	<i>У.Гонгоржав “Дундад зууны түүхийн дээж бичиг”-ээс,</i> 37, 48, 62-р тал. <i>Эх сурвалжийн мэдээнээс.</i> 29, 49, 125, 127, 128-р тал.	37, 38 (2 эх сурвалж), 41, 96, 98, 198-р тал. <i>У.Гонгоржав. Дундад зууны дээж бичиг”, Г.Сүхбаатар, Л.Жамсран. Монголын түүхийн дээж бичиг.</i>	21, 68, 109-р тал.
Эх сурвалжийн нэр, он цагийг заагаагүй.			5, 32, 62, 97-р тал	95, 106-р тал

Эх сурвалжийн зохиогч, он цагийг заагаагүй			14, 18, 29-р тал	
Эх сурвалжийн бүтэн нэр, зохиогчийг заагаагүй	79-р тал 2 эх сурвалж <i>Хан улсын судрын мэдээгээр</i>			
Тайлбар				
	7 эх сурвалжаас 2 тохиолдолд эх сурвалжийн он цаг, бүрэн нэршлийг заагаагүй	27 эх сурвалжаас 14 нь ялангуяа дэлхийн түүхэнд холбогдох эх сурвалжийн тодорхойлолт бүрэн бус	Олон эх сурвалжийн он цагийг заагаагүй (15 эх сурвалж). Нэр, зохиогч заагаагүй эх сурвалж цөөнгүй. 41 эх сурвалжаас 30 нь бүрэн тодорхойлолтгүй	30 эх сурвалжаас 9 нь бүрэн тодорхойлолтгүй.

Эх сурвалж: Судлаачийн загвар

Эх сурвалжийн нэр, зохиогч, он цагийн аль алиныг нь заагаагүй тохиолдол цөөнгүй байна. Жишээ нь VI ангийн сурах бичгийн 73-р талд “Эх сурвалж 2:” гэж оруулсан 1 эх сурвалж (зүй нь *Сыма Цянь Ши зи буюу “Түүхэн тэмдэглэл”, “Хүннүгийн тухай” бүлэг*) мөн “Түүх VII” сурах бичигт “Эх сурвалжийн мэдээнээс” гэсэн 5 эх сурвалж байна.

Эх сурвалжийн нэр заагаагүй, ямар эмхэтгэлээс авсан нь тодорхойгүй жишээ олон байна. VI ангийн сурах бичигт “НТӨ 176 онд Модунь шаньюй Хан улсын хуандид бичсэн захидалд” (зүй нь *Бань Гу. Хан шу буюу Хан улсын шастираас*), VIII ангийн сурах бичигт “Манжийн анхны хаан Нурхачийн хэлсэн үг”, “Лигдэн хааны захидлаас” (зүй нь *Дайчин гүрний дотоод яамны монгол бичгийн гэрийн данс, II дэвтэр, Эрхлэн хэвлүүлсэн Цанжид А., УБ., 2010*), “XII Людвик (1498-1515)-ийн зарлигаас” (зүй нь *XII Луй. “Шүүх ба хаант улсын хэв журмыг хамгаалах тухай зарлиг. 1498 оны 3-р сар. “Isambert, Recueil General des anciens lois francaises depuis l’an 420 cusu’a la Revolution de 1789”. 1821-1833. (420 оноос 1789 оны Францын хувьсгал хүртлэх эртний Францын хуулийн эмхэтгэлээс), “XIV Людвигийн хэлсэн үг”, “1844 онд Монголоор аялсан Францын жуулчин Е.Р. Гюкд нэгэн хятад худалдаачны ярьсан зүйл” (зүй нь, *Путешествие через Монголию в Тибет, к столице Тале-ламы. Сочинение Гюки, Габэ. Москва. 1866.*) гэсэн нь ийм нэртэй бие даасан эх сурвалж байдаг гэх төөрөгдөлд хүргэж болно.*

Мөн IX ангийн сурах бичгийн 66-р талд “Коминтерны төлөөлөгч Б.Шмераль 1928, 1934 онуудад Монголд ирж, зүүнтнүүдийн болчимгүй үйл хэргийн талаар илтгэж хэлсэн үгээс” гэсэн нь 1928, 1934 гэсэн хоёр оны аль онд, хаана, ямар хуралд хэлсэн нь тодорхойгүй байх жишээтэй” (зүй нь *МАХН-ын IX их хуралд оролцсон Коминтерны Гүйцэтгэх ТХ-ны төлөөлөгчдийн ажлын үр дүнгийн тухай Коминтерны Гүйцэтгэх ТХ-ны тэргүүлэгч нарын 1934 оны 11-р сарын 10-ны*

хуралдаан дээр нөхөр Шмералийн хэлсэн үгээс. Монголия документах Коминтерна (1919-1934). В 2-х ч. Ч.П. (1930-1934). Стр.387).

Мөн эх сурвалжийн нэрийг заалгүй зөвхөн эмхэтгэлийн нэрийг дурдсан тохиолдол байна. Жишээ нь, VII ангийн сурах бичигт “У. Гонгоржав. Дундад зууны түүхийн дээж бичиг”, VIII ангийн сурах бичигт “Дундад зууны түүхийн дээж бичиг”, “Г.Сүхбаатар, Л.Жамсран Монголын түүхийн дээж бичиг”, Л.Жамсран “Монголын түүхийн дээж бичиг” гэсэн нэртэй эх сурвалжууд байх юм. Зүй нь эхлээд зохиогч, эх сурвалжийн нэр, он цагийг зааж, улмаар ямар эмхэтгэлээс авснаа дурдах ёстой. Үүнээс гадна нэг эх сурвалжийн нэрийг олон янзаар бичсэн нь бий. Жишээ нь, VI ангийн сурах бичигт зохиогч Фань Е-гийн “Хожуу Хан улсын судар” (*Хоу Хань Шу*)-ын хоёр ч мэдээ ашигласан нь “Хожуу Хан улсын судрын мэдээгээр”, Хан улсын судрын Ухуаны шастирт” (*зүй нь эхнийх нь Фань Е. Хожуу Хан улсын судар*” 90-р бүлэг *Сяньбийн шастир, хоёр дахь нь Фань Е. Хожуу Хан улсын судар. 90-р бүлэг. Ухуаны шастир*) гэсэн хоёр өөр нэртэй, IX ангийн сурах бичгийн 59-60-р талд нэг эх сурвалжийг “БНМАУ-ын анхдугаар үндсэн хуулиас”, “БНМАУ-ын анхны үндсэн хуулиас, “1924 оны үндсэн хууль” гэж гурван янзаар нэрлэсэн байх юм.

Олон эх сурвалжийн он цагийг заагаагүйг эдгээр сурах бичгээс харж болно (Хүснэгт 2).

Түүхийн эх сурвалжаас зөв эшлэх нь багагүй ач холбогдолтой, эс бөгөөс энэ нь бичгийн сурвалжийн утга, өнгө аясыг алдагдуулах, түүний хэр хэмжээг буруу ташаа төсөөлөхөд хүргэдэг, ач холбогдлыг нь ч бууруулдаг. Жишээ нь, VII ангийн сурах бичгийн “Загалмайтны сүмийн хүчирхэгжилт ба аян дайнууд” сэдэвт ашигласан “Пап лам VII Григорийн (1073-1085) зарлигаас” хэмээх эх сурвалжийг дурдаж болно. Энэ нь пап VII Григорийн 1075 онд хэвлүүлсэн 27 зүйл баримт бичиг бөгөөд сурах бичигт 3, 8, 9, 12-р зүйлийг ашиглахдаа (“*зарлигаас*” хэмээн тодотгосон ч) өмнөх дугаарыг заагаагүй, мөн VI ангийн сурах бичгийн “Монгол угсааны Сяньби, Жужан улс” хэмээх сэдэвт “Вэй улсын судар”-ын 103 дугаар бүлгээс хэсэглэн авахдаа үргэлжилсэн өгүүлбэр мэтээр бичсэн, зүй нь хоёр ч газар гурван цэг авч, үг, өгүүлбэр орхин товчлон авсан болохыг ялгах, мөн “103 дугаар бүлэгт бус бүлгээс” гэж тодруулах нь зүйтэй юм. Ийм жишээ бусад сурах бичигт цөөнгүй байна.

Зохиогч, нэр, он цаг, тодорхойгүй байхын зэрэгцээ эх сурвалжийн он цаг нь агуулгатайгаа тохирохгүй, мэдээ нь эргэлзээтэй цөөн эх сурвалж байна. Жишээ нь, IX ангийн сурах бичгийн “Дэлхийн II дайн” сэдэвт ашигласан “Дэлхийн дайны дараах Орос орны нөхцөл байдлыг дурсан бичсэн сэтгүүлчийн тэмдэглэл”-ээс хэмээх эх сурвалжид “1941 онд нэгэн сурвалжлагч Германы байлдан дагууллын өмнө 10000 хүн амьдарч байсан Оросын нэгэн хотод зочилсон тухай өгүүлжээ. “*Сурвалжлагч ганцхан амьд үлдсэн хүнийг олжээ. “Тэрхүү өндөр настай сохор эмэгтэйн ухаан санаа самуурсан байлаа. Тосгоныг газрын зургаас арчиж байхад тэр хэдийнээ галзуурчихсан байв. Тосгоны ойролцоо ноорхой хувцас, хөл нүцгэн гайхширсан янзтай алхаж байхыг нь би харсан юм” гэж тэр сурвалжлагч бичжээ* “гэжээ (Амарсанаа, 2019, хууд. 109). Эх сурвалжийн нэрэнд “*дайны дараа*” гэсэн хэрнээ мэдээлэл нь 1941 онд гэж эхэлж байна. Мөн аль улсын, хэн гэдэг сэтгүүлч, 1941 онд Оросын аль хотод очоод тухайн үеийн байдлыг нүдээр харсан

нь тодорхойгүй, мөн хот уу, тосгон уу? гэдэг нь ч эргэлзээтэй байна. Мөн ЗХУ-д нацист Герман халдан довтолсон үйл явдлыг “германы байлдан дагуулал” мэтээр нэрлэх нь зохимжгүй болов уу.

Мөн VIII ангийн сурах бичгийн “XV-XVIII зууны Өрнө дахин” сэдэвт ашигласан “XIV Людвикийн (1661-1715 он) хэлсэн үг” хэмээх эх сурвалжид буй “Төр бол би” хэмээх алдарт эшлэл түүхийн шинжлэх ухаанд ихээхэн маргаан дагуулдаг бөгөөд 1655 оны 4-р сарын 13-нд (сурах бичигт хааны төр барьсан он цагийг ташаарсан, хоёр янзаар бичсэн) 16 настай Францын хаан XIV Людвиг (Луй, 1643-1715) Парисын парламентад хэлсэн гэх, хожим түүхч Пьер Эдуард Лемонте 1818 онд хэвлүүлсэн “Etablissement monarchique de Louis XIV” (XIV Луй хааны үеийн хаант засгийн тухай) зохиолд дурдсан мэдээллээс зөрүүтэй байна. Уг эх сурвалжид XIV Луй хаан “Энэ хурал миний улсад хичнээн хэв журамгүй үйлдэл ургуулж, тэдгээрээс хичнээн аюултай үр дагавар бий болсныг бүгд мэднэ. Та бүхэн саяхан миний гаргасан зарлигуудыг шүүн хэлэлцэх нэрээр энэ үйлдлээ үргэлжлүүлэхийг хүсэж байгааг би олж мэдлээ. Уг хэлэлцүүлгийг хориглохын тулд би зориуд энд хүрэлцэн ирлээ. Ноён парламентын дарга [танд хэлэхэд] үүнээс болж, тэдгээрийг хүлээн зөвшөөрөхгүйгээс болж би зовж шаналахыг хүсэхгүй байна...” гэжээ. Тэрээр хэлсэн үгэндээ “Төр бол би” хэмээн шууд хэлээгүй, ийм санааг илэрхийлсэн гэж судлаачид үздэг (Серов, 2005, хуудсд. 191-192).

Өөр нэг анхаарал татаж байгаа зүйл бол сурах бичигт ашигласан эх сурвалжийн хэмжээ, үгийн тоо юм. Энэ нь хичээлд хэрэглэх бичгийн сурвалжийг сонгон авахад тусгайлан тавигддаг шалгуурын¹ нэг юм (Никол, 2001). Түүхийн сургалтын арга зүйн ном, бүтээлд 10-15 мөр буюу 80-120 орчим үгтэй байх тохиромжтой гэж үздэг (Студеникин, 2000, хууд. 134). Гэтэл эдгээр сурах бичигт хэсэглэн авч ашигласан бичгийн сурвалжийн үгийн тоо дунджаар 40 орчим байна. 1-2 өгүүлбэр буюу 7-10 үгтэй эх сурвалж ч байна. VI ангийн сурах бичгийн 7 эх сурвалжийн 2, VII ангийн сурах бичгийн 27 эх сурвалжаас 90 удаа хэсэглэн авснаас 65 нь, VIII ангийн 29 эх сурвалжаас 41 удаа хэсэглэн авснаас 21 нь, IX ангийн сурах бичгийн 30 эх сурвалжаас 34 удаа хэсэглэн авснаас 14 нь үгийн тоо шаардлагатай хэмжээнд хүрэхгүй байна.

Эсрэгээр нэг сэдэвт олон үгтэй, том эх сурвалжуудыг ашигласан нь бий. Жишээ нь, VIII ангийн сурах бичгийн “XV-XVIII зууны монголчуудын амьдрал” сэдэвт 70, 120, 150 үгтэй гурван эх сурвалж, IX ангийн “Монголын түүхэн дэх хар толбо” сэдэвт 130, 140, 200 үгтэй гурван эх сурвалжийг ашиглажээ. Эдгээрийг нэг сэдвийн хүрээнд сурагчид задлан шинжлэх боломжгүй бөгөөд бичгийн сурвалж нь сурагчдын нас, танин мэдэхүйн боломжид нийцэж байх шаардлагыг харгалзан үзээгүй байна (Хүснэгт 3).

1 Шалгуурыг дурдвал: Сургалтын зорилго, зорилт, хөтөлбөрийн агуулгад нийцсэн, 2. тухайн үеийн гол, нийтлэг баримт, үйл явдлыг тусгасан, 3. суралцагчдад танин мэдэхүйн асуулт, даалгавар өгч болохуйц, 4. агуулга, хэр хэмжээ нь сурагчдад тохирсон, сонирхолтой, ахуйн болон адал явдалт үйл явдлыг тусгасан, 4. ялгавартай сургалтыг хэрэгжүүлэхүйц, 5. аль нэг үйл явдал, үзэгдэл, үйл явцын тухай сурагчдын төсөөллийг баяжуулах, тэдэнд сэтгэл хөдлөлийн тодорхой нөлөө үзүүлэхүйц, 6. уран зохиол, шинжлэх ухааны хувьд үнэ цэнтэй, 7. бие даасан танин мэдэх үйл ажиллагаа, оюуны хөдөлмөрийн арга барилыг хөгжүүлэхүйц хангалттай мэдээлэлтэй байх”

Хүснэгт 3. Сурах бичигт орсон бичгийн сурвалжууд сонгон авах шалгуурт нийцсэн байдал

Бичгийн сурвалжийг сонгон авах шалгуурт нийцсэн байдал	Сурах бичиг			
	Түүх VI	Түүх VII	Түүх VIII	Түүх IX
Сургалтын зорилго, зорилт, хөгөлбөрийн агуулгад нийцсэн	+	+	+	+
Тухайн үеийн гол, нийтлэг баримтыг тусгасан, уран зохиол, шинжлэх ухааны хувьд үнэ цэнтэй	+	+	62-р тал <i>XIV Людвик (1661-1715)-ийн хэлсэн үг</i>	109-р тал <i>Дайны дараах Орос орны нөхцөл байдлыг дурсан бичсэн сэтгүүлчийн тэмдэглэлээс</i>
Агуулга, хэр хэмжээ нь сурагчдад тохирсон (10-15 мөр буюу 80-120 орчим үгтэй) Танин мэдэхүйн асуулт, даалгавар төлөвлөж болохуйц, Танин мэдэх бие даасан үйлийн арга барилыг хөгжүүлэх хангалттай мэдээлэлтэй байх	7 эх сурвалжаас 3 эх сурвалжийн үгийн тоо цөөн (26-53 үгтэй)	27 эх сурвалжаас 90 удаа хэсэглэн авснаас 65 нь буюу 72% нь үгийн тоо хэт цөөн (7- 42 үгтэй)	29 эх сурвалжаас 41 удаа хэсэглэн авснаас 21 эх сурвалж буюу 50% нь үгийн тоо цөөн байна.	18, 48, 60, 62, 66, 68, 69, 70, 76, 94 (2 эх сурвалж), 95, 135 (2 эх сурвалж) 30 эх сурвалжаас 34 удаа хэсэглэн авснаас 14 эх сурвалж буюу 41% нь үгийн тоо хэт цөөн байна.
	Тайлбар			
	4 сурах бичигт орсон 93 бичгийн сурвалжаас 172 удаа хэсэглэн авснаас 103 эх сурвалжийн үгийн тоо цөөн байна.			

Эх сурвалж: Судлаачийн загвар

Судалгааны үр дүн

Эх сурвалжийг задлан шинжлэх асуулт, даалгаврыг сурвалж судлалын судалгааны үе шатуудад нийцүүлэн эх сурвалжийг тодорхойлох, агуулгыг задлан шинжлэх, эх сурвалжийн мэдээллийг үнэлэх, эх сурвалжийн мэдээллийг ашиглан бүтээлч даалгавар гүйцэтгэх гэсэн алхмаар боловсруулдаг. Бид мөн сурах бичгийн бичгийн сурвалжтай ажиллах асуулт, даалгаварт дүн шинжилгээ хийж, дээрх алхамд нийцсэн эсэхийг тодруулсан юм.

VI-VII ангийн сурах бичигт бичгийн сурвалжтай ажиллах асуулт, даалгаврыг тусгайлан боловсруулсан байна (Хүснэгт 4).

VI ангийн сурах бичгийн “Дэлхийн эртний улсууд” бүлгийн нэг эх сурвалжид 2 асуулт, “Монголын эртний улсууд” хэмээх бүлэг сэдвийн 6 эх сурвалжид 9 асуулт, даалгавар төлөвлөснөөс тодорхой түүхэн үед холбогдох эх сурвалжийг нэрлэх, эх сурвалжийг тодорхойлох, эх сурвалж дахь мэдээллийн жагсаалт гаргах 5 асуулт, гол санааг илэрхийлэх, дүгнэх, таамаглал дэвшүүлэх 4 даалгавар орсон байна.

VII ангийн сурах бичгийн 90 эх сурвалжид 169 асуулт, даалгавар төлөвлөснөөс 120 нь эх сурвалжид дурдсан мэдээллийг нэрлэх, давтан өгүүлэх асуулт байгаа бол 44

нь эх сурвалжийн агуулгыг задлан шинжлэх, мэдээллийг үнэлэх, ашиглах, бүтээлч даалгавар гүйцэтгэхэд чиглэжээ.

VIII, IX ангийн сурах бичгийн сэдэв бүрийг шинжлэн судлах аргын үе шатаар төлөвлөж, бичгийн сурвалжийг мэдээллийн бусад эх сурвалжтай (*зохиогчийн эх, газарзүйн зураг, он тооллын шугамд тэмдэглэсэн мэдээлэл, сургалтын зураг*) нэгтгэн сэдвийн төгсгөлд бүхэлд нь задлан шинжлэх асуулт, даалгавар боловсруулсан байна.

VIII ангийн сурах бичгийн “Үр дүнг нэгтгэх, танилцуулах” хэсэгт орсон асуултуудаас зөвхөн эх сурвалжийн мэдээнд холбогдох хэсгийг ялган авч үзэхэд, *“сурвалжийн мэдээнд тулгуурлан шинжлээрэй”, “тодруулан тайлбарлаарай”, “задлан шинжилж, тодорхойлоорой”, “баримт, мэдээллийг задлан шинжлээрэй”, “баримт, мэдээллийг шинжлэн судлаарай”, “эх сурвалжийн агуулгыг задлан шинжилж, бүлэглэж, ангилж, өөрийн дүгнэлт өгөөрэй”* зэргээр эх сурвалжийг задлан шинжлэх даалгаврыг маш олон янзаар томъёолсон байна.

Зүй нь эх сурвалжтай ажиллах асуулт, даалгавар нь эх сурвалжийг задлан шинжлэхэд сурагчдыг хөтөлж, задлан шинжлэх үйлийн аргад сургах ёстой.

Сурагчдын гүйцэтгэсэн даалгаварт дүн шинжилгээ хийсэн судлаачид ихэнх сурагч задлан шинжлэх, харьцуулах, нэгтгэн дүгнэх, ерөнхийлөн дүгнэх зэрэг үйлийн арга, алхамын тухай ихэнхдээ ойлголтгүй, тиймээс даалгаврыг гүйцэтгэж чаддаггүй тухай тэмдэглэсэн байдаг. Тухайлбал, Оросын судлаач Л.Н.Алексашкина “Түүхийн хичээлээр улсын нэгдсэн шалгалт авч эхэлсэн үеэс зарим төгсөгч харьцуулах үйлийн тухай мэдэхгүй, ойлгохгүйгээс болж, ийм даалгаврыг гүйцэтгэж чадахгүй байгаа нь тодорхой болсон. Улмаар харьцуулах даалгаврын зааварчилгааны хэсэгт хариултыг хэрхэн томъёолохыг харуулсан логик бүдүүвч оруулснаар зөв хариултын тоо нэмэгдсэн” гэж тэмдэглэжээ (Алексашкина, 2011, хуудсд. 16-25).

IX ангийн сурах бичигт ч мөн ийм төрлийн даалгавар голлож байгаагаас гадна *“анхдагч эх сурвалжид үндэслэн хүмүүсийн аж амьдрал, үзэл бодлыг төсөөлөөрэй, мэдрээрэй”, “сурвалж болон мэдээлэл тус бүрийн агуулгыг шүүн хэлэлцэнэ үү”, “эх сурвалжуудыг уншаад төрсөн сэтгэгдлээ хуваалцаарай”, “эх сурвалжийн мэдээллээс юу ойлгож авснаа эргэцүүлээрэй”, “бие даан судалж, тунгаан бодоорой”, “төсөөлж сэргээгээрэй”* зэрэг танин мэдэх ямар үйл хийх нь эргэлзээтэй даалгаврууд ч байна.

VII, VIII, IX ангийн сурах бичгүүдийн Монголын түүхийн сэдвүүдэд олон эх сурвалж ашигласан ч эх сурвалжийн мэдээллийг харьцуулах, нийтлэг ба ялгааг тодорхойлох асуулт, даалгавар тун цөөн байна. Тухайлбал, дээр дурдсанчлан IX ангийн сурах бичгийн “Монголын түүхэн дэх хар толбо” сэдэвт “Гэндэнгээс Амарт бичсэн захидал”, “ЗХУ-ын цэргийн коллегийн шүүхийн хаалттай хуралдаанд өгсөн А.Амарын мэдүүлгээс”, “Ц.Лоохууз гуайн дурсамжаас” гэсэн гурван эх сурвалжаас ашигласан ч “анхдагч эх сурвалжийг үндэслэн хүмүүсийн аж амьдрал, үзэл бодлыг төсөөлөөрэй, мэдрээрэй” гэсэн нэг л асуулт төлөвлөжээ.

Хүснэгт 4. VI-IX ангийн сурах бичигт орсон бичгийн сурвалжтай ажиллах асуулт, даалгаврын төрөл

Анги	Эх сурвалжын тоо	Асуулт, даалгаврын тоо	Эх сурвалжийг тодорхойлох, мэдээлэл олж авах						Задлан шинжлэх			Үнэлэх, бүтээх
			Төрлүүд			Төрлүүд			Төрлүүд			
			Эх сурвалж, түүний төрлийг тодорхойлох, хойшээ жишээ гаргах	Эх сурвалжийг уншин нэрлэсэн (эх сурвалжийн агуулгыг давтан өгүүлэх) асуултад хариулах	Эх сурвалжаас авсан мэдээллийн жагсаалт гаргах, хүснэгт, бүдүүвч зохиох, зурагт заах	Эх сурвалжийн он цагийг тодорхойлох стандарт бус бодлого бодох	Эх сурвалжид гарч буй үгийн утгыг тайлбарлах	Эх сурвалжид ...тухай ноу өгүүлснийг тодорхойлох	Учир шалтгааныг тогтоох	Эх сурвалжуудын мэдээг харьцуулах, нэгтгэн дүгнэх	Эх сурвалжийг уншин асуулт гаргаж, мэдээллийг үнэлэх, асуудал, таамаглал дэвшүүлэх	
VI анги	7	9	3		1	1	1		2		1	1
VII анги	27/90	169	4	103	7	3	8		7	24	9	4
VIII анги	29/41	24				1				22		1
IX анги	30/34	17	1							15		1
		218	8	103	8	4	8		9	61	10	7

Эх сурвалж: Судлаачийн загвар

Оросын судлаач И.Я.Лернер түүхийн хичээлээр эх сурвалжийг судлуулахдаа эхлээд нэг эх сурвалжийг сонгон ажиллуулах, улмаар нэг л үйл явдлын тухай өгүүлж буй, ойролцоо цаг үед зохиогдсон эх сурвалжуудыг харьцуулан судлуулах, дараа нь өөр цаг үед бүтээгдсэн ч түүхийн баримтын интерпретацийн хувьд ижил эх сурвалжийг харьцуулан задлан шинжлэх, эцэст нь өөр, өөр хэв хаягийн эх сурвалжуудыг зэрэгцүүлэн судлуулах зэргээр эрэмбэ, дэс дараатай судлах нь үр дүнтэй гэж зөвлөсөн байдаг (Лернер, 1982, хууд. 45).

Түүнчлэн эдгээр асуултын дотор тухайн эх сурвалжаа задлан шинжлэхэд огтын хамааралгүй асуултууд байгааг ч дурдах хэрэгтэй. Жишээ нь, VIII ангийн сурах бичгийн 20-р талд *“харциргэн эзэнгүй, яахинявна” хэмээсэн үгийн утгыг тайлбарлан ярилцаарай. Бусад улсын түүхээс ийм төстэй жишээ олж харьцуулаарай*”, 26-р талд *“Түүхийн сурвалжид “төрөөс этгээд явдал” гэж юуг хэлсэн гэж бодож байна? Тунгаан бодоорой”* гэжээ. Гэтэл тухайн сэдэвт ашигласан эх сурвалжид ийм мэдээ огт дурдагдаагүй байна.

Мөн эх сурвалжийг задлан шинжлэхэд төдийлөн чухал биш асуултууд ч байна. Тухайлбал, VIII ангийн сурах бичгийн 19-р талд Лувсанданзангийн *“Алтан товч”* зохиолоос хэсэглэн авч, тайлбарт нь Ин зун хааныг 1449 онд олзолсон гэсэн атал асуултад *“Мин улсын Ин зун хааныг буцаах тухай хэлэлцээр хэддүгээр жарны хэдэн онд болсныг тооцоолоорой”* гэсэн даалгавар өгчээ. Хуанлийн онуудыг харилцан шилжүүлэх даалгавар нь хуучны, өөр он цагаар бичигдсэн эх сурвалжийн он цагийг одоо хэрэглэж буй хуанлийн онд шилжүүлж, түүхэн цаг хугацааг баримжаалахад чиглэдэг. Харин он цагийг тодорхой заасан тохиолдолд хуанлийн өөр онд шилжүүлэх нь ач холбогдолгүй, мөн асуулт ч оновчгүй, *“билгийн тооллын хэддүгээр жарны ямар жилд болсныг тооцоолоорой”* гэх нь зөв юм.

Эх сурвалжийг задлан шинжлэх даалгавар нь сурагчдын чадварыг анги ахих тусам хялбараас хүнд гэсэн эрэмбээр хөгжүүлэх хөтөлбөрийн шаардлагад огт нийцээгүй, залгамж холбоогүй байна.

Дүгнэлт

Ийнхүү ЕБС-ийн VI-IX ангийн түүхийн сурах бичигт ашигласан бичгийн сурвалж, асуулт даалгаварт дүн шинжилгээ хийн дараах дүгнэлтэд хүрч байна. Үүнд:

VI-IX ангийн сурах бичигт Монголын болон дэлхийн түүхийн эрт, дунд, шинэ, нэн шинэ үед холбогдох 93 эх сурвалжаас 172 удаа эшилж ашигласан нь сурагчид эдгээр сурвалжтай танилцан танин мэдэхэд чухал ач холбогдолтой байна.

Сурах бичигт ашигласан бичгийн сурвалжийн тоо түүхийн хичээлийг үзэж судлах цагийн тооноос хамаарч харилцан адилгүй, VI ангид түүхийн хичээлийг 7 хоногт нэг цагаар үзэж судалдаг тул хамгийн цөөн буюу 7 эх сурвалж ашигласан бол 7 хоногт 2 цагаар үздэг VII-IX ангид 27-30 эх сурвалж ашиглажээ. Гэхдээ Монголын түүх, дэлхийн түүхэнд холбогдох эх сурвалжийн сонголт жигд бус, VII-VIII ангийн сурах бичигт ашигласан 27-29 эх сурвалжийн 50 орчим хувь нь Монголын түүх, үлдсэн нь дэлхийн түүхийн сэдвүүдэд холбогдож байгаа бол *“Түүх IX”* сурах бичигт ашигласан 30 эх сурвалжаас 2 нь дэлхийн түүхийн эх сурвалж байна.

Зохиогчид Монголын болон дэлхийн түүхийн сэдвүүдэд холбогдох түүхийн судалгаанд нэн чухал, үнэ цэнтэй эх сурвалжийг сонгон авахад анхаарсан ч олон эх

сурвалжийн зохиогч, нэр, он цагийг бүрэн заагаагүй, 93 эх сурвалжаас 40 нь бүрэн тодорхойлолтгүй, зөв эшлээгүй, эх сурвалжийг сонгох шалгуурт бүрэн нийцээгүй, 172 удаа эшилснээс 103 эх сурвалжийн үгийн тоо хэт цөөн, зарим эх сурвалжийн мэдээ эргэлзээтэй байна.

Эх сурвалжтай ажиллах 218 асуулт, даалгавраас 131 нь эх сурвалжийг тодорхойлох, мэдээллийн жагсаалт гаргах, 80 нь агуулгыг задлан шинжлэх, 7 нь эх сурвалжийн мэдээллийг үнэлэх, эх сурвалжийн мэдээллийг ашиглан бүтээлч даалгавар гүйцэтгэх асуулт, даалгавар байгаа нь эх сурвалжтай ажиллах доод эрэмбийн чадвар эзэмшүүлэх асуулт, даалгавар голлож байна.

Бичгийн сурвалж угаас сургалтын зориулалтгүй учир, зохиогчийн бичвэрээс ялган сэдвийн гол, нийтлэг, чухал асуудлыг тусгасан эх сурвалжийг сурагчдын танин мэдэх боломж, эх сурвалжийг сонгон авах шалгуурт нийцүүлэн тусгайлан авч, судлуулах, задлан шинжлэх асуулт, даалгаврыг алхамчлан иж бүрэн боловсруулах нь чухал байна. 2017 онд түүхийн 70 багшаас авсан судалгаагаар багш нарын 57,1% нь зөвхөн сурах бичигт орсон эх сурвалжийг хичээлд ашигладаг гэсэн тул сурах бичгийн бичгийн сурвалжийн сонголт, хэр хэмжээ, асуулт, даалгавар эх сурвалжтай ажиллах сурагчдын танин мэдэх бие даасан үйлийг арга зүйн үндэстэй зохион байгуулахад үлгэр болох учиртай.

Ном зүй

Алексашкина, Л. (2011). О системном подходе к развитию умений школьников при изучении истории в основной и старшей школе. *Преподавание истории и обществознания в школе*. №5, 16-25.

Амарсанаа, С. н. (2019). *Түүх IX. ЕБ-ын 12 жилийн сургуулийн 9 дүгээр ангийн сурах бичиг*. Улаанбаатар: БСШУЯ.

Гантулга, Ц. н. (2019). *Түүх VIII. ЕБ-ын 12 жилийн сургуулийн 8 дугаар ангийн сурах бичиг*. Улаанбаатар: БСШУЯ.

Лернер, И. (1982). *Развитие мышления учащихся в процессе обучения*. Москва: Педагогика.

Никол, Д. (2001). *Ремесло учителя истории*. Ярославль: Яросл. гос. пед. ун-т им. К. Д. Ушинского.

Серов, В. (2005). *Энциклопедический словарь крылатых слов и выражений*. Москва: Локкид-Пресс.

Студеникин, М. (2000). *Методика преподавания истории в школе*. Владос: Владос.

ANALYSIS OF WRITTEN SOURCES, QUESTIONS, AND TASKS USED IN HISTORY TEXTBOOKS OF GRADES VI-IX OF SECONDARY SCHOOL

^aBayarmaa.Kh

^aSchool of Social and Humanities, MNUE

Corresponding author: Bayarmaa.kh@msue.edu.mn 

Abstract

Summary. This article examines history textbooks and written sources used in history textbooks for grades VI-IX of general education. At the same time, they considered whether the authors, names and dates of these sources (attributes), their relevance to the topic and compliance with the criteria for selecting written sources were clearly indicated. Issues and tasks related to working with written sources are also analyzed. Let us note that, in general, the authors of all these publishing houses have done a great job of collecting documents from different eras. It is good that written sources are used so widely, but there are many issues for further attention and improvement, which will be discussed in the article. The correct selection of written sources for use in textbooks, the rational formulation of questions and tasks for their analysis will help organize the independent cognitive activity of students on a correct and methodological basis.

Keywords

historical sources, written sources, attributes of sources, criteria for selecting sources, issues and tasks of source analysis.